



АЖ, АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДАД

**УЛСЫН ХОЁРДУГААР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 49, Утас/Факс: (976) 7015 0308
И-мэйл: info@ssch.gov.mn, Вэб: www.ssch.gov.mn

2023.12.27 № 3/1034
танай _____-ны № _____-т

Үнийн санал авах урилга

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн “Тусгай тасаг”-т шаардлагатай цахилгаан халаагуур худалдан авах ажлыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан журмын дагуу зохион байгуулж байна. Иймд техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан бараа нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

“Худалдан авах барааны техникийн тодорхойлолт”-ыг хамт хавсралтад хавсаргав.

Үнийн саналыг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 10.00 цагаас өмнө procurement@ssch.gov.mn цахим хаягаар болон цаасан хэлбэрээр ирүүлнэ үү.

Цаасаар ирүүлэх үнийн саналыг дугтуйнд хийж, битүүмжлэн доорх хаягаар ирүүлнэ үү.

Үнийн санал хүлээн авах болон шаардлагатай мэдээллийг өгөх хаяг: БЗД-ийн 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-49, УХТЭ-ийн Б-байрны 2 давхар 201 тоот. Утас: 99559035

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 12:00 цагт Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 201 тоот өрөөнд нээнэ.

ЗАХИРАЛ



Я.АМАРЖАРГАЛ